

**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХАРГУЙ ТӨХК-ИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/87/СТА-ТӨҮГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2018 он



Аудитын код: САГ-2018/87/СТА-ТТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn


Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор Б.Сэржмядаг
Утас: 261740 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

“Монголиан бизнес рейтинг аудит” ХХК
Ерөнхий захирал Д.Түмэнжаргал
Ахлах аудитор Ш.Нурдаулет
Утас: 70005329 Цахим хаяг: mbr.audit.llc@gmail.com

Улаанбаатар хот





ХАРГУЙ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ч.АЛТАНЗАЯА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.14 № 06/649
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Харгуй ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт


Харгуй ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударгаар илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Харгуй ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.




Үүрэг, хариуцлага

Харгуй ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.


Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichg_Kheregl\Yawsan_Bichg\2019\08150\AS000001



Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	3
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин гүйцэтгэлийн талаарх тодруулга ..	4
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар	5
2.9	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	5
2.10	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.10.1	Мөнгөн хөрөнгийн талаар.....	5
2.10.2	Авлагын талаар.....	5
2.10.3	Эзний өмчийн талаар	6
2.10.4	Шилэн дансны талаар.....	6
2.11	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	6
2.12	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.13	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	7
2.14	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	6
2.15	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	7
2.16	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3	Менежментийн захидал	8
3.1	Авлагын талаар	9
3.2	Эзний өмчийн талаар.....	10
3.3	Шилэн дансны талаар.....	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшингийн гүйцэтгэл	12
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.5	Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл	16



2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Харгуй ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Харгуй ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Доржханд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Харгуй ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшингийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, найдваргүй авлагын нөөцийг тооцон байгуулж, авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр үнэлж бүртгэх, насжилт өндөртэй авлагыг барагдуулах, шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг иж бүрэн мэдээлж байх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Харгуй ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэлд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Харгуй ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Гүйцэтгэх удирдага нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн байгууллагын санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САГ-2018/87/СТА-ТӨҮГ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

1
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Харгуй ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 2 дугаар сарын 07-ноос 2018 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Монголиан бизнес рейтинг аудит ХХК-ийн Ерөнхий захирал Д.Түмэнжаргал, ахлах аудитор Ш.Нурдаулет, аудиторын туслах Ө.Рагчаа, Б.Ганчимэг нар хэрэгжүүлж ажиллав.

Харгуй ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 08-ний өдрийн 1/07-01 дугаартай албан бичгээр Монголиан бизнес рейтинг аудит ХХК-д ирүүлсэн болно. Энэ нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулинд заасан цагалбар хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Харгуй ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, 2014 оны 249 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Харгуй ТӨХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Авто тээврийн тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Шилэн дансны тухай, Нийгмийн даатгалын багц хууль, Татварын багц хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Архивын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Харгуй ТӨХК нь “Улсын чанартай авто замын засвар арчлалт, шугамын хэсгүүдийг шуурхай удирдлагаар хангаж, хариуцсан авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, гарсан эвдрэл, гэмтлийг арилгах ажлыг зохион байгуулж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх нөхцлийг бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилготой ажиллаж байна.

Дээрх эрхэм зорилгын дагуу дараах зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Үүнд:

- Улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг төрийн захиргааны байгууллагатай байгуулсан “Зам засвар, арчлалтын гэрээ”-ний дагуу Хэнтий аймгийн хэмжээнд зохион байгуулж, түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн хангаж ажиллах,
- Шинжлэх ухааны тодорхой салбарын шинжилгээ судалгааны орчин үеийн арга барилыг эзэмшихэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах,
- Шинэ технологи, норм норматив, дүрмийг хэрэгжүүлж ажиллах,
- Иргэд, аж ахуйн нэгжид шударга үйлчилгээ үзүүлэх,
- Зөвхөн хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах,
- Хайрган болон хатуу хучилттай авто зам, модон гүүр барилгын байгууллага



2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Харгуй ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс гүйцэтгэх удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 30 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/


Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 1,552.7 сая төгрөгийн 1 хувиар тооцож 15.5 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В1/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох төвийн “Лидер-3.0” програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3-д “Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журамтай байна” гэж заасантай нийцүүлэн Гүйцэтгэх захирлын 2015 оны А/65 дугаар тушаалаар “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг баталсан, 2016 оны А/39 дугаар тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг байгуулсан, 2017 оны 04 дүгээр сарын А/36 дугаар тушаалаар дотоод хяналтын нэгжийн бүрэлдэхүүнийг шинэчилсэн байна. Дотоод хяналтын нэгж болон өмч хамгаалах байнгын зөвлөл нь тайлант онд хийх ажлын төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний биелэлт, шалгалтын ажлын тайланг компанийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр хугацаатай албан даалгавар өгч, биелэлтийг сар бүр гаргуулан авч ажилласан байна. Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.2-д заасны дагуу компанийн Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутамын хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



2.6 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 300 дугаар тогтоолоор баталсан Харгуй ТӨХК-ийн 2017 оны "Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө"-өөр улсын чанартай зам засвар арчлалтын санхүүжилтээр 940.0 сая төгрөг, орон нутгийн чанартай зам арчлалтын санхүүжилтээр 80.0 сая төгрөг, нийт орлого 1,020.0 сая төгрөг, нийт зардал 1,012.1 сая төгрөг, татварын өмнөх ашиг 7.9 сая төгрөг, цэвэр ашиг 2.2 сая төгрөг, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлыг 0,99 төгрөгөөр баталсан байна.

Орлогын гүйцэтгэл: Улсын чанартай зам засвар арчлалтын санхүүжилтээр 923.9 сая төгрөг, орон нутгийн чанартай зам арчлалтын санхүүжилтээр 579.6 сая төгрөг, бусад орлого 47.1 сая төгрөг, хүүний орлого 2.0 сая төгрөг, нийт 1,552.7 сая төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 50.9 хувиар буюу 532.7 сая төгрөгөөр, зорилтот түвшиний төлөвлөгөөтэй харьцуулахад 52.2 хувиар буюу 524.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Зардлын гүйцэтгэл: Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 1,056.1 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардал 383.1 сая төгрөг, бусад зардал 69.5 сая төгрөг, нийт 1,508.7 сая төгрөгийн зардалтай ажиллаж, зардлын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 13.9 хувиар буюу 176.0 сая төгрөгөөр, төлөвлөгөөтэй харьцуулахад 49.1 хувиар буюу 496.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант оны орлого, зардлын өсөлт нь орон нутгийн чанартай зам арчлалтын ажлын санхүүжилтээр хийсэн ажлын өсөлттэй холбоотой байна.


Үр дүн цэвэр ашиг: Тайлант онд 39.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, цэвэр ашгийн төлөвлөгөөг 5.6 дахин буюу 32.5 сая төгрөгөөр давуулан биелүүлж, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал 0,97 төгрөг болж, төлөвлөгөөг 2.0 хувиар буюу 0,02 төгрөгөөр бууруулсан байна.

Авлага, өглөг: Өмнөх оны мөн үеэс богино хугацаатай авлага 306.4 сая төгрөгөөр өсч, богино хугацаат өр төлбөр 430.5 сая төгрөгөөр буурсан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Харгуй ТӨХК-ийн 2017 онд Шилэн дансны тухай хуулийн дагуу төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор гаргасан удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар шилэн дансны вебсайт хуудсанд байршуулсан мэдээллийг шалгаж үзэхэд орлого, зардал, удирдлагын шийдвэр, санхүүжилт, тендер шалгаруулалт, худалдан авалт зэрэг ажил гүйлгээний талаарх мэдээллийг shilendans.gov.mn сайтад байршуулж олон нийтэд толилуулж байна.

Шилэн дансны вебсайт хуудсанд байршуулсан мэдээллээс зарим мэдээллийг сонгон авч шалгахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан ашиг сонирхлын мэдэгдэлийг гэрээ хэлцэл байгуулах, хөрөнгө захиран зарцуулах тушаал шийдвэр гаргах бүрдээ 7 хоногийн дотор байршуулах ёстой бөгөөд хэрэгжилтийг шалгахад огт мэдээлээгүй байна.



2.8 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Харгуй ТӨХК нь Гүйцэтгэх захирлын 2017 оны А/130 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлдээ мөрддөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм, журам, СТОУС-тай нийцсэн байна.

Харгуй ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Санхүүгийн тооцоолох төвийн Лидер-3.0 програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу бэлтгэж, гаргасан байна. Энэхүү програм нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, СТОУС-тай бүрэн нийцэхгүй байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ өгч, аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

2.9 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын уламжлалт болон хяналтын 42 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр тулган баталгаажуулалт, болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.


2.10 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.10.1 Мөнгөн хөрөнгө: Төрийн банкин дахь 250000039926 тоот харилцах дансны шимтгэлийн 2.0 мян.төгрөгийн зардлыг илүү бүртгэж, тайлагнаснаас тайлант оны үр дүнг бууруулж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг дутуу тайлагнасан нь СТОУС 1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

2.10.2 Авлагын талаар

Авлага өмнөх оноос 306.4 сая төгрөгөөр өссөн байгаа нь Улаанбаатар Өндөрхаан чиглэлийн А0501 кодтой авто замын их засвар, шинэчлэлтийн 17 км замын ажлыг концессийн гэрээгээр гүйцэтгэсэн Наранбулагхан ХХК, Анандын зам ХХК-тай туслан гүйцэтгэгчийн гэрээгээр 1 км замын ажлыг гүйцэтгэсэн ажлын санхүүжилт он дамжсан, мөн 3 ба түүнээс дээш жилийн насжилттай 103.6 сая төгрөгийн авлагатай холбоотой байна. Үүнээс Монгол дайвин ХХК-аас авах 2014 онд үүссэн 81.6 сая төгрөгийн авлагыг 2017 онд шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Сангийн сайдын 2014 оны 249 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын нэгдүгээр хавсралтын 2.1.2 дахь хэсгийн заалтын дагуу “найдваргүй авлагын нөөцийг тооцож байгуулж байх” гэж заасантай нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр үнэлж бүртгэх, насжилт өндөртэй авлагыг барагдуулж ажиллах талаар зөвлөмж өгөх.

2.10.3 Эзний өмч, түүний бүртгэлийн талаар

Эзний өмчийг санхүүгийн байдлын болон өмчийн өөрчлөлтийн тайланд 435.8 сая төгрөгөөр, улсын бүртгэлийн гэрчилгээнд 77.8 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэж, тайлагнасан нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэлийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх.

2.10.4 Шилэн дансны талаар

Шилэн дансны вебсайт хуудсанд байршуулсан мэдээллээс зарим мэдээллийг сонгон авч шалгахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан ашиг сонирхлын мэдэгдэлийг гэрээ хэлцэл байгуулах, хөрөнгө захиран зарцуулах тушаал шийдвэр гаргах бүрдээ 7 хоногийн дотор байршуулах ёстой бөгөөд хэрэгжилтийг шалгахад огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-д “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь заалтыг хэрэгжүүлж, шилэн дансын мэдээллийг иж бүрэн мэдээлж байх талаар аудитын зөвлөмж өгөх.

2.11 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.12 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД


Харгуй ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад цалингийн бодолт; цагийн бүртгэлийг гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулж амжаагүй болно.

2.13 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛЭЙН НЭГТГЭЛ

Харгуй ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 105.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, аудитын явцад 2.0 мян. төгрөгийн алдааг залруулж, 103.6 сая төгрөгийн зөрчил нь суурь шинжтэй тул материаллаг бус гэж үзэж зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж зөвлөмж өгсөн болно.

2.14 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн програмд шинэчлэл хийлгэх, авлагыг баталгаажуулж, барагдуулж ажиллах талаар 2 зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.



2.15 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгов.

Нийт орлогын дүнгээс материаллаг түвшинг сонгон авсан шалтгаан нь компанийн тайлант оны орлогын гүйцэтгэл нь зорилтот түвшингийн төлөвлөгөөгөөр батлагдсан орлогоос 52.2 хувиар буюу 515.6 сая төгрөгөөр давж биелсэн байв. Иймд нийт орлогын гүйцэтгэл нь тайлант хугацааны үйл ажиллагааг төлөөлж чадахуйц суурь үзүүлэлт гэж үзлээ.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 1,552.7 сая төгрөгийн 1 хувиар тооцож 15.5 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Аудитаар шинж чанар, орчны нөхцлөөр материаллаг зүйл илрээгүй болно.

2.16 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Харгуй ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Харгуй ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.


Энэ нь Харгуй ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардаг дахь цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар нь эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага найдваргүй авлагын нөөцийг тооцож байгуулаагүй, авлага өмнөх оноос 306.5 сая төгрөгөөр өссөн байна. Үүнээс 3 ба түүнээс дээш жилийн насжилттай 103.6 сая төгрөгийн авлага байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Сангийн сайдын 2014 оны 249 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын нэгдүгээр хавсралтын 2.1.2 дахь хэсгийн заалтын дагуу “найдаргүй авлагын нөөцийг тооцож байгуулж байх” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Сангийн сайдын 2014 оны 249 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 2.1.2 дахь хэсгийн заалтыг хэрэгжүүлж, авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр үнэлж бүртгэх, насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах


Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хууль, Сангийн сайдын заавар журмын заалт зөрчигдөж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд зөрчигдөх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2 Эзний өмч, түүний бүртгэлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Эзний өмчийг санхүүгийн байдлын болон өмчийн өөрчлөлтийн тайланд 435.9 сая төгрөгөөр, улсын бүртгэлийн гэрчилгээнд 77.8 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэж, тайлагнасан байна. Энэ нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан бүртгэлийн мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн эзний өмч Улсын бүртгэлийн гэрчилгээнд үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.3 Шилэн дансын талаар**Тэргүүлэх ач холбогдол №3****ҮАГ-ын ажиглалт**

Шилэн дансны вебсайт хуудсанд байршуулсан мэдээллээс зарим мэдээллийг сонгон авч шалгахад Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан ашиг сонирхлын мэдэгдлийг гэрээ хэлцэл байгуулах, төсөв хөрөнгө захиран зарцуулах тушаал шийдвэр гаргах бүрдээ 7 хоногийн дотор байршуулах ёстой бөгөөд хэрэгжилтийг шалгахад огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-д “Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь заалтыг хэрэгжүүлж, шилэн дансны мэдээллийг иж бүрэн мэдээлж байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Удирдлага болон шийдвэр гаргагчдыг буруу мэдээллээр хангах
Хууль тогтоомж, журам, заавар зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	224,415,695.08	209,128,594.00 ✓
1.1.2	Дансны авлага	118,570,553.73	425,266,476.42 ✓
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	821,355.63	597,499.29 ✓
1.1.6	Бараа материал	228,203,601.34	161,156,954.94 ✓
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	572,011,205.77	796,149,524.65
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,067,063,772.42	2,884,828,228.76 ✓
1.2.2	Биет бус хөрөнгө	506,458.33	272,708.33 ✓
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,067,570,230.75	2,885,100,937.09
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,639,581,436.52	3,681,250,461.73
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1.1	Дансны өглөг	1,423,050.01	-
2.1.1.3	Татварын өр	422,560.00	992,510.21
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,845,610.01	992,510.21
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,845,610.01	992,510.21
2.3	Эзэмшигчдийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	435,863,563.44	435,863,563.44
2.3.6	Хөрөнгийн дахын үнэлгээний нэмэгдэл	57,055,110.00	57,055,110.00 ✓
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	3,217,558,066.00	3,220,487,986.00 ✓
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(72,740,912.94)	(33,148,707.93)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	3,637,735,826.50	3,680,257,951.51
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	3,639,581,436.50	3,681,250,461.71



4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,018,793,324.55	1,544,642,606.45 ✓
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	915,596,623.53	1,056,133,786.35 ✓
3	Нийт ашиг (алдагдал)	103,196,701.01	488,508,820.11
4	Түрээсийн орлого	-	2,727,272.73
5	Хүүний орлого	3,533,668.22	2,021,409.70
6	Мал аж ахуйн орлого	6,753,784.97	1,594,011.49
10	Ерөнхий ба удирдлагын зардал	282,050,184.53	383,071,095.62
12	Бусад зардал	36,501,139.01	69,519,732.83 ✓
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	1,730,653.33
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(205,067,170.23)	43,991,338.90
19	Орлогын татварын зардал	353,366.82	4,399,133.89 ✓
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(205,420,537.05)	39,590,405.01
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(205,420,537.05)	39,592,205.01
27	Орлогын нийт дүн	(205,420,537.05)	39,592,205.01 ✓
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-



4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн ТАЙЛАН
Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хөрөнгийн дахын үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2016 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	435,863,563.44	3,217,558,066.00	57,055,110.00	132,679,624.11	3,843,156,363.55
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	435,863,563.44	3,217,558,066.00	57,055,110.00	132,679,624.11	3,843,156,363.55
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(205,420,537.05)	(205,420,537.05)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дөхын үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-
2017 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	435,863,563.44	3,217,558,066.00	57,055,110.00	(72,740,912.94)	3,637,735,826.50
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	435,863,563.44	3,217,558,066.00	57,055,110.00	(72,740,912.94)	3,637,735,826.50
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	39,592,205.01	39,592,205.01
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	2,929,920.00	-	-	2,929,920.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дөхын үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	435,863,563.44	3,220,487,986.00	57,055,110.00	(33,148,707.93)	3,680,257,951.51

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЭЛТ

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЭЛТ


4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,453,185,342.22	1,399,029,284.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,435,687,693.00	1,372,186,284.00
	Бусад мөнгөн орлого	17,497,649.22	26,843,000.00
1.2	Мөнгөн зарлага (-)	1,260,810,338.77	1,416,337,794.78
	Ажиллагчдад төлсөн	323,394,346.00	309,101,178.00 ✓
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	94,059,279.00	95,243,754.00 ✓
	Бараа материал худалдан авахад төлсөн	264,521,975.00	297,391,272.85 ✓
	Ашиглалтын зардалд төлсөн	18,663,213.00	32,805,419.00 ✓
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	301,689,522.50	360,427,131.14 ✓
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	121,163,704.00	149,277,606.00
	Даатгалын төлбөрт төлсөн	6,847,870.00	7,428,506.00
	Бусад мөнгөн зарлага	130,470,429.27	164,662,927.79
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	192,375,003.45	(17,308,510.78)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	2,021,409.70
	Хүлээн авсан хүүний орлого	-	2,021,409.70
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	27,409,500.00	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	27,409,500.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(27,409,500.00)	2,021,409.70
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	164,965,503.45	(15,287,101.08)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	59,450,191.63	224,415,695.08
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	224,415,695.08	209,128,594.00

САГ-2018/87/СТА-ТӨҮГ



ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016		2017		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Нийт орлого	сая.төг	1,140.0	1,029.0	1,020.0	1,552.7	152.23
2	Үүнээс: Үндсэн борлуулалт	сая.төг	1,140.0	995.7	990.0	1,503.5	151.87
	Улсын чанартай зам засвар арчлалтын ажил	сая.төг	1,010.0	995.7	940.0	923.9	98.29
	Орон нутгийн чанартай зам засвар арчлалтын ажил	сая.төг	-	-	50.0	579.6	1,159.27
	Бусад	сая.төг	130.0	33.4	30.0	49.2	163.90
3	Нийт зардал	сая.төг	1,137.6	1,234.1	1,012.1	1,508.7	149.07
5	Татварын өмнөх ашиг, алдагдал	сая.төг	2.4	(205.1)	7.9	43.9	557.93
6	Цэвэр ашиг, алдагдал	сая.төг	2.2	(205.4)	7.1	39.6	557.93
7	Борлуулалтын 1%-т ноогдох зардал	сая.төг	0.99	1.20	0.99	0.97	97.51
8	Төсвийн нийт төлбөр	сая.төг	102.0	250.0	150.0	243.2	162.16
9	Үүнээс: Ноогдол ашиг	сая.төг	0.24	-	0.32	-	-
10	Нийт ажиллагсдын тоо	сая.төг	65.0	59.0	59.0	59.0	100.00
11	Цалингийн сан	сая.төг	400.0	402.7	357.2	402.4	112.64
12	Хөрөнгө оруулалт	сая.төг	29.5	27.4	-	-	-
13	Үүнээс: Их засвар	сая.төг	-	-	-	-	-
14	Нийт авлага	сая.төг	5.5	119.4	10.5	425.8	4,055.85
15	Нийт өглөг	сая.төг	1.0	1.8	1.5	0.9	66.17
16	Үүнээс: Богино хугацаат өглөг	сая.төг	1.0	1.8	1.5	0.9	66.17

